



“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР” ХХК-ИЙ  
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ  
Ц. ДАВААЦЭРЭН ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.12.17 № 149

**ЗӨРЧЛИЙГ АРИЛГАХ ТУХАЙ**

Үндэсний аудитын газрын 2013 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ий 2012 он, 2013 оны эхний 9 сарын санхүүгийн зарим үйл ажиллагаанд эрсдлийн аудит хийхэд дараах зөрчил илэрлээ.

Хүдрийн ил уурхайн цехийн захиалгаар бэлтгэн нийлүүлсэн “HITACHI EX1900-6” маркийн урвуу хутгуурт экскаваторыг “Таван богд трейд” ХХК-аас 2012 оны 7 дугаар сард 4,977.5 мянган ам.доллараар буюу зах зээлийн үнээс өндөр үнээр шууд гэрээгээр худалдан авсан боловч уг экскаваторыг ашиглахад эдийн засгийн хувьд үр ашиггүй байна гэсэн үндэслэлээр одоо болтол хадгалагдаж байгаа ба энэхүү хөрөнгөнд 2013 оны 9 дүгээр сарын 30-ны байдлаар нийт 369.3 сая төгрөгийн элэгдэл байгуулсан байгаа нь ЗГ-ын 2005 оны 233 дугаар тогтоолоор баталсан “Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох журам”-ын 2.2-т “түр ашиглаагүй буюу нөөцөд байгаа үндсэн хөрөнгөнд элэгдэл тооцохгүй” гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-д “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар баталсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ыг үндэслэн дээр дурьдсан 369.3 сая төгрөгийн байгуулсан элэгдлийг залруулах бичилт хийхийг “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ий Ерөнхий нягтлан бодогч Платонов М.В-д үүрэг болгож албан шаардлага хүргүүлж байна.

Албан шаардлагын биелэлтийг 2014 оны 3 дугаар сарын 31-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг мэдэгдье.

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН  
АУДИТОР**

ТАНИЛЦАЖ ЗӨВШӨӨРСӨН

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ

**Д.ГАНДОЛГОР**

ПЛАТОНОВ М.В



070395